

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Уластай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

дод 4-001-дБ № 17д

талай _____ -ны № _____ -т

ЗАВХАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Г.МЯГМАРСҮРЭН-Д

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Биеийн тамир, спортын улсын хорооноос спортын арга хэмжээ зохион байгуулах зориулалтаар шилжиж ирсэн 70,000.0 мянган төгрөгийг аймгийн 100-н жилийн ойн хүлээн авалт болон морины бай шагналын зардалд, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас баяр наадмын үйл ажиллагаанд зориулан, нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн зардлаас "Завхан-100" хүндэтгэлийн арга хэмжээнд оролцох албан хаагчдын унааны зардалд 4,500.0 мянган төгрөг, "Steppe Arena" төрийн бус байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулсан томилолтын хуудсаар 6,512.0 мянган төгрөгийн албан томилолт олгосон, хүндэт зочдын буудлын төлбөрт 5,980.0 мянган төгрөг, хоолны зардалд 13,378.1 мянган төгрөг, гарын бэлэг худалдан авах зардалд 16,360.0 мянган төгрөгийг тус тус зориулалт бусаар зарцуулсан, үндсэн үйл ажиллагааны зардлаас байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалтын зардалд 8,400.0 мянган төгрөг зарцуулсан нь сургалт хийснийг нотлох тайлан, бусад холбогдох баримтгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, төрийн байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй ажлаар явсан, нутгийн зөвлөл, баяр наадмын комисс болон төрийн бус байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулсан томилолтын хуудсаар 19,199.0 мянган төгрөгийн, албан ёсны дуудсан бичиггүйгээр явсан ажилд 4,544.0 мянган төгрөгийн, дуудсан албан бичгээс 1-4 хоногээр илүү 4,218.0 мянган төгрөгийн томилолтыг тус тус тооцон олгож, албан томилолтын зардлыг үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3-д "Хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх", 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад",

15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", 15.2.3-т "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, тохиолдсон байх, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Засаг даргын Тамгын газар нь тайлант онд 39,299.3 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 64,971.5 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 99,9811.8 мянган төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагын шийдвэрээр акталж, 8,350.1 мянган төгрөгийн хөрөнгийг төсөвт байгууллагуудад шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар 24 албан хаагчид 2,364.1 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдлийг илүү тооцож олгосон, аймгийн 100-н жилийн ойгоор идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан албан хаагчдад үнэ бүхий зүйл дурсгаж, гарын бэлэг худалдан авах зардалд 9,925.0 мянган төгрөг зарцуулсан, өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн болон тэтгэвэрт гарсан албан хаагчдад Хөдөлмөрийн дотоод журамд заасан гэх үндэслэлээр 1,400.0 мянган төгрөгийн тэтгэмж, Төрийн одон медалиар шагнуулсан 2 албан хаагчид 400.0 мянган төгрөгийн дагалдах мөнгөн шагнал олгосон, ойн үйл ажиллагаанд 12,483.6 мянган төгрөгийн шатахууныг үрэлгэн зарцуулсан, аймгийн Засаг даргын зөвлөхийн орон тоонд 2 ажилтан ажиллуулж, 21,800.0 мянган төгрөгийн цалин олгосон зэрэг зөрчил байна.

Бусад асуудлын хэсэг

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгийн бүртгэлд үлдэх өртөггүй 278,784.7 мянган төгрөгийн 191 нэр төрлийн хөрөнгө байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Д.БАТ-УНДРАА